**2024 ОНЫ СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЖИЛИЙН ЭЦСИЙН ХЭРЭГЖИЛТ**

| *Бүтэц* | *№* | *Бодлогын баримт бичигт тусгагдсан, болон үндсэн чиг үүргээ хэрэгжүүлэх зорилт, арга хэмжээ* | *Шалгуур үзүүлэлт* | Хэмжих нэгж | Суурь түвшин | *Төлөвлөсөн онд хүрэх түвшин* | | | *2024* | *Зорилтот оны түвшин /2024/* | *Хариуцах байгууллага* | *Хувь* |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | *2021* | *2022* | *2023* | | | | |
| ***Ерөнхий чиг үүргийн нэр: 7*** **Орон нутгийн өмчийн удирдлага** | | | | | | | | | | | | |
| ***Үндсэн чиг үүргийн нэр: 1*** **Орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой хуулийн этгээдийг удирдлагаар хангах, өмчийн бодлого, шийдвэр хэрэгжүүлэх** | | | | | | | | | | | | |
| Зорилт | 1 | Орон нутгийн өмчийн хөрөнгийн ашиглалтыг сайжруулна. | Хөрөнгийн ашиглалт | Хувь | 70 | 75 | 80 | 85 | 90 | Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн ашиглалтгүй байгаа хөрөнгийн эргэлтэд оруулан худалдан борлуулж боломжит хувилбарын дагуу түрээсэлж, хөрөнгийн ашиглалтыг сайжруулах талаар анхаарч хяналт тавин ажиллаж байна. Орон нутгийн өмчит 11 сум, 24 байгууллагын 130 иргэн, хуулийн этгээдээс 2024 оны 11 | ОНӨГ | 100 |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | сарын 07-ны өдрийн байдлаар түрээсийн орлогын дансанд 17.7 сая төгрөгийн орлого төвлөрүүлсэн. Түрээслэх боломжтой хөрөнгийг 100 хувь түрээслэн ашиглаж байна. | | |
| Арга хэмжээ | 1 | Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн эзэмшилт, захиран зарцуулалтын байдалд бүртгэлээр хяналт тавих | Тухайн жилд хамрагдсан орон нутгийн өмчит хуулийн этгээдийн тоо | тоо | 142 | 40 | 142 | 113 | 29 | Аймгийн Засаг даргын 2024 оны 06 дугаар сарын 05-ны өдөр баталсан “Орон нутгийн өмчийн эд хөрөнгөд хяналт шалгалт зохион байгуулж, арга зүйн дэмжлэг үзүүлэх ажлын удирдамж”-ын дагуу 2024 оны 06 дугаар сарын 10-ны өдрөөс эхлэн 15 сумын 100 байгууллага, аймгийн төвийн 24 байгууллагуудын өмч хөрөнгийн байдал, хөрөнгийн ашиглалт, хадгалалт хамгаалалтын байдал, өмч хамгаалах зөвлөлийн үйл ажиллагаанд үнэлэлт, дүгнэлт өгч цаашид анхаарах зүйлс болон хэрэгжүүлэх арга хэмжээг зөвлөмж | ОНӨГ | 100 |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | хэлбэрээр хүргүүлэн ажиллалаа. Тайлант хугацаанд 15 сумын “Эм эргэлтийн сан” ОНӨААТҮГ-ыг татан буулгах шийдвэр гарсан, мөн Эрдэнэдалай сумын Хүүхэд хөгжлийн ордон, Худалдан авах ажиллагааны газар шинээр байгуулагдсан, “Эрдэм шинжилгээ туршилт үйлчилгээний төв” ОНӨААТҮГ үйл ажиллагаа явуулаагүй, удирдлага солигдсон үндэслэлээр хяналт шалгалтад хамрагдах шаардлагагүй болсон.<br><br>Үр дүн:<br><br> Бүх байгууллагуудын өмч хамгааллын байнгын зөвлөлийн гишүүдийг идэвхжүүлэх сургалтад хамруулсан.<br><br> Хяналт тавьсан бүх байгууллагууд руугаа зөвлөмж хүргүүлж хяналтаар илэрсэн | | |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | зөрчлүүдийг арилгуулсан.<br><br>11 сумын эм эргэлтийн санг татан буулгахаар ИТХ-д материалыг хүргүүлсэн тул тухайн байгууллагуудаар хяналт шалгалтад хамрагдаагүй. | | |
| | 2 | Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн ашиглалтгүй байгаа хөрөнгийг эдийн засгийн эргэлтэд оруулан ашиглалтыг сайжруулах | Орлого төвлөрүүлэх хувь | Хувь | 80 | 85 | 90 | 95 | 95 | Орон нутгийн өмчит 11 сум, 24 байгууллагын 130 иргэн, хуулийн этгээдтэй “Орон нутгийн өөрийн өмчийн түрээсийн гэрээ”-г байгуулан орлого төвлөрүүлэлтэд хяналт тавин ажиллаж байна. 2024 оны 11 сарын 07-ны өдрийн байдлаар түрээсийн орлогын дансанд 17.7 сая төгрөгийн орлого төвлөрүүлээд байна. Мөн орон нутгийн өмчит 2 байгууллагын 2 ширхэг тээврийн хэрэгслийг акталж, сэлбэг хэрэгслээр ашиглах 9 байгууллагын 12 тээврийн хэрэгсэл, 7 барилгыг нээлттэй | ОНӨГ | |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | 3 | | | | | | | | | дуудлагын худалдаагаар худалдан борлуулж орон нутгийн хөрөнгө борлуулсны орлогын дансанд 118.6 төгрөг, Орон сууц хувьчлалын орлогоос 21.1 сая төгрөг нийт 139,7 сая төгрөгийн орлого төвлөрүүлээд байна.<br>**Үр дүн:**<br>✓ Ашиглалтгүй байгаа хөрөнгийг эдийн засгийн эргэлтэд оруулж орлого төвлөрүүлсэн<br>✓ 2023 оны Орлого 53,000,000 байсан бол 2024 оны 11 дүгээр сарын байдлаар 139,7 сая төгрөгийн орлого төвлөрүүлсэн.<br>Хэрэгжилтийн хувийг өмнөх оноос 4%-р нэмэгдүүлсэн. | | |
| | 3 | Улсын болон орон нутгийн төсөв, гадаад дотоодын | Үндсэн хөрөнгийг | Хувь | 85 | 90 | 93 | 95 | 100 | **Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар:** | ОНӨГ | ЫЛ |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | зээл, тусламж хандив болон бусад эх үүсвэрээр хийгдсэн үндсэн хөрөнгийг орон нутгийн өмчид бүртгэх | бүртгэсэн хувь | | | | | | | 1.Адаацаг суманд барьж ашиглалтад оруулсан 1,995,145,705 төгрөгийн өртөгтэй ЕБС-ын Спорт заалны барилга<br>2.Луус суманд барьж ашиглалтад оруулсан 895,391,326 төгрөгийн өртөгтэй ЕБС-ын 80 хүүхдийн дотуур байрны барилга<br>3.Дэлгэрцогт суманд барьж ашиглалтад оруулсан 2,447,379,693 төгрөгийн өртөгтэй Хүүхдийн цэцэрлэгийн барилга<br>4.Сайнцагаан суманд барьж ашиглалтад оруулсан 2,710,000,000 төгрөгийн өртөгтэй Хүүхдийн цэцэрлэгийн барилга<br>5.Сайнцагаан суманд барьж ашиглалтад оруулсан 10,147,291,762 төгрөгийн өртөгтэй Нэгдсэн эмнэлгийн барилга тус бүрийн үндсэн хөрөнгөд бүртгэх аймгийн ИТХ-ын | | |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | тогтоолыг гаргуулж, хэрэгжилтийг ханган ажиллаж ТӨБЗГ-т хүргүүллээ.<br><br>**Орон нутгийн хөрөнгө оруулалтаар:**<br><br>6.Гурвансайхан сумын орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар 34.7 сая төгрөгийн “Халуун усны барилга”<br><br>7.“Аймгийн төвд ангилан ялгах хогийн сав, дахивах цуглуулах сав байршуулах” 36,000,000<br><br>8.Сургуулийн өмнөх боловсролын ‘’Урлаг, биеийн тамирын хичээлд шаардлагатай тоног төхөөрөмж” 36,942,400<br><br>9.Сайнцагаан сумын Мандал сургуульд “Аяга таваг ариутгалын тоног төхөөрөмж” 16,500,000<br><br>10.Сумдын Эрүүл мэндийн төвүүдэд шаардлагатай тоног төхөөрөмж 130,800,000 | | |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | 11.Сайнцагаан сумын Говийн Ирээдүй цогцолбор сургууль, Хүмүүнлэг сургуулиудад мэдээлэл зүйн "SMART" кабинет байгуулах 234,415,720<br><br>12.Боловсрол, соёлын үйлчилгээнд дунд оврын автобус 224,890,000<br><br>13.Нэгдсэн эмнэлэгт шаардлагатай тоног төхөөрөмж /гал тогоо, угаалга ариутгалын, мэс заслын багаж хэрэгсэл, ухаалаг дэлгэц/ 231,500,000<br><br>14.Сайнцагаан сумын 2-р цэцэрлэгт тоглоом тоног төхөөрөмж /Шимт тоглоом, Хөл бөмбөгийн талбай/ 50,000,000<br><br>15.Онцгой байдлын газрын албан хэрэгцээнд үерийн ус зайлуулах помп 43,450,000 төгрөгийн өртөгтэй хөрөнгүүд тус тус бий болж, нийлүүлэгдлээ.<br><br>Азийн хөгжлийн банкны зээлийн хөрөнгөөр “Зүүн | | |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | өмнөд говийн хот байгуулалт, хилийн орйролцоо суурин газруудын хөгжлийн МОН-3713” төслийн хүрээнд аймгийн төв болон Эрдэнэдалай суманд цэвэрлэх байгууламж, машин механизм, багаж, тоног төхөөрөмж зэрэг нийт 12,237,128,072.02 төгрөгийн хөрөнгө бий болсон. ТӨБЗГ-аас орон нутгийн өмчлөлд бүртгэх тогтоол ирүүлсний дагуу материалыг бэлтгэн аймгийн ИТХ-д оруулж, 2024 оны 36 дугаар тогтоол гарсныг Дундговь-Ус ОНӨААТҮГ-т хүргүүлэн ажиллалаа .<br><br>Улсын төсөв, ОНХС-ын хөрөнгө оруулалтаар Дундговь аймагт хийгдсэн "Мандал хорооллын гадна шугам сүлжээ, халаалтын зуухны барилга угсралтын ажил" нийт 1,147,159,228 /нэг тэрбум нэг зуун дөчин долоон сая нэг зуун | | |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | тавин есөн мянга хоёр зуун хорин найм/ төгрөгийн өртөгтэй барилга байгууламж, тоног төхөөрөмжүүдийг "Дундговь-Ус" ОНӨААТҮГ-ын хөрөнгөд бүртгүүлэх хүсэлтийг ТӨБЗГ-т хүргүүллээ.<br>**Үр дүн:**<br>✓ Нийт 12,237,128,072.02 төгрөгийн үнийн дүн бүхий хөрөнгийг бүртгэсэн. | | |